



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 140

Номгон

Г 7


“Үндэсний спортыг хөгжүүлэх” аймгийн
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “ж”, 20 дугаар зүйлийн 20.1.7, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 2/3 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 45 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Үндэсний спортыг хөгжүүлэх” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гарган аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг бүтэн жилээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.



011.107

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын
29-ний өдрийн 140 дүгээр тогтоолын хавсралт



**“ҮНДЭСНИЙ СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ”
АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР**

Нэг. Нийтлэг үндэслэл

Үндэсний спорт нь тухайн ард түмний уламжлал, зан заншилд тулгуурлан хөгжсөн үндэстний онцлог шинжийг агуулсан байдаг бөгөөд улс үндэстэн бүр өөрийн орны үндэсний спортоо хөгжүүлэх, үр хүүхэд, өсвөр үедээ залгамжлуулан үлдэх, дэлхий нийтэд таниулах, сурталчлахад ихээхэн анхаарал тавьдаг.

Монгол улс үндэсний спортоо өвлүүлэх, хөгжүүлэх, дэлхий дахинд таниулах, сурталчлах чиглэлээр томоохон арга хэмжээнүүд хэрэгжүүлдэг. Үндэсний баяр наадмын хуультай улс төдийгүй 4 жилд 1 удаа үндэсний спортын их наадмыг зохион байгуулж хэвшсэнээр үндэсний спортоор хичээллэгсэд өсч, монгол хүн бүр үндэсний спортоо дээдлэх үзэл төлөвшиж байна.

Сүүлийн жилүүдэд үндэсний шагайн харваа, үндэсний сурын харваа хөгжиж, аймгийн аварга шалгаруулах тэмцээн, цомын аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулдаг болсон нь үндэсний сур, шагайн спортоор хичээллэх, сонирхох хүрээг тэлж байна.

Үндэсний спортыг хөгжүүлэх чиглэлээр орон нутгийн удирдлагууд хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх, бодлого шийдвэр гаргаж хэрэгжүүлсний үр дүнд Баянхонгор аймгийн үндэсний спортын амжилт өсч, спортын холбоодын үйл ажиллагаа сэргэж, спортын байгууллагуудтай хамтран ажиллаж, ажлын уялдаа холбоо сайжирч байна.

Үндэсний бөхийн холбоо, үндэсний сурын холбоо, үндэсний шагай холбоо, “Хонгорын хурд” морин спортын уяачдын холбоо үйл ажиллагаа явуулж байна. Мөн сум бүрт Морин спортын уяачдын холбооны салбар, үндэсний шагайн харвааны салбар холбоо, 14 сум бөхийн, 10 суманд сурын холбоо ажиллаж орон нутагт үндэсний спортоор хичээллэгчдийн тоо жил бүр өсч байна. Үндэсний спортоор хичээллэгчдийн амжилтаас дурдвал улсын арслан-1, гарыд-1, заан-1, харцага-1, начин-15, Монгол улсын мэргэн-1, үндэсний шагайн улсын алдартанууд 17 байдаг. Үндэсний бөхөөр хичээллэгчид 800 гаруй хүүхэд, сурын хичээллэгчид, сонирхогчид 300 гаруй, үндэсний шагайгаар 700 гаруй хүн хичээллэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Биеийн тамир, спортын эрх зүйн орчинг боловсронгуй болгож нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, үндэсний спортын өв соёлыг хөгжүүлэх, өвлөн уламжлах бодлого, тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлнэ”, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсанаар “Үндэсний спортыг хөгжүүлэх цогц бодлогыг хэрэгжүүлнэ” гэсэн зорилт нь энэхүү хөтөлбөрийн үндэслэл болж байна.

Хоёр. Хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага

Уламжлагдан ирсэн үндэсний спорт, тоглоом наадгай монгол хүний онцлогт тохирсон олон сайхан өв уламжлалыг шингээсэн хувь хүний бие бялдарын хүмүүжлийг дээшлүүлэхэд ихээхэн ач холбогдолтой.

Үндэсний спортын холбоодын үйл ажиллагаа тогтмол бус, хичээллэх байр, материаллаг бааз дутмаг, бөхчүүд, уяачид, харваачид, шагайчдыг дэмжих, алдаршуулах орчин бүрдээгүй, орон нутгийн бүтэц тогтолцоогүй, хүүхдийг бага наснаас нь үндэсний спортоор хичээлүүлэх, хөгжүүлэх орчин бүрдээгүй, нутгийнхаа алдартай тамирчдын дараагийн үе болон дасгалжуулагчдыг бэлтгэдэггүй, дадлага туршлагыг өвлүүлдэггүй, тусгайлан үндэсний спортоо хөгжүүлэх бодлого хөтөлбөр, санхүүжилт байхгүй байна.

Цаашид үндэсний спортоор дамжуулан хүн амын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, орон нутгийн биеийн тамир спортын байгууллага, үндэсний спортын холбоодын ажлын уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтанд оруулах дасгалжуулагчдыг бэлтгэх, бэлтгэлийн орчинг бүрдүүлэх, хөрөнгө санхүүг шийдвэрлэх, үндэсний спортын улсын чанартай уралдаан тэмцээнийг орон нутагт зохион байгуулж, сонирхогч, хичээлэгчдийн тоо нэмэгдүүлэх, бага наснаас нь хүүхдийг үндэсний спортом дуртай болгож, амжилт гаргасан тамирчдыг урамшуулах, алдаршуулах, дараагийн үеэ бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, нутаг усныхаа алдартануудаар бахархах, олон алдартануудтай болж, аймаг, сум, багийнхаа нэр хүндийг аймаг, улсын түвшинд хүргэх таниулах, бахархан дуурайлган хөгжүүлэх, бие бялдар, гоо зүйн хүмүүжил олгох зэрэг арга хэмжээнүүдийг бодлогоор хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагатай байна.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, хугацаа, зарчим, санхүүжилт

3.1. Зорилго: Үндэсний спортыг хөгжүүлэх бүтэц тогтолцоо бий болгож, боловсон хүчин, материаллаг бааз, санхүүгийн орчинг бүрдүүлж, улс, аймгийн алдар цолтой шилдэгүүдийг төрүүлж, алдаршуулан, хонгорчуудын бахархал, үнэт соёл, баялгийг бүтээхэд олон нийтийн оролцоог хангах

3.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа: Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

3.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

3.3.1 Үндэсний спортыг хөгжүүлэх үйл ажиллагаа нь төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж, иргэний хамтын ажиллагаанд тулгуурласан байх.

3.3.2 Үндэсний спортын морь, бөх, сур, шагайн, уран уургач, бугуйлч, эмнэг булгиулагчдын залгамж халааг бэлтгэх

3.3.3. Үндэсний спортыг орчинг бүрдүүлэхэд бүх талын дэмжлэг авах

3.3.4. Хүн бүр үндэсний спортоороо бахархах, уламжлалт ёс зүйг эрхэмлэх

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн,

хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Хөтөлбөрийн зорилт

Зорилт 1. Үндэсний спортыг хөгжүүлэх бүтэц тогтолцоо бий болгож, боловсон хүчин, материаллаг бааз, санхүүгийн орчинг бүрдүүлнэ.

Хүрэх үр дүн: Баянхонгор аймагт үндэсний спортыг хөгжүүлэх тогтолцоо, эрх зүйн орчин бүрдсэн байна.

1.1. Аймгийн үндэсний спортыг хөгжүүлэх бүтэц тогтолцоо бий болгох

1.2. Үндэсний спортыг хөгжүүлэх дасгалжуулагчдын бэлтгэх, урьж ажиллуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх

1.3. Үндэсний спортын арга зүйч, багш дасгалжуулагч нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх талаар онцгой анхаарч аймгийн Биеийн тамир, спортын газар, Монголын Үндэсний Олимпын хороо, үндэсний спортын холбоодоос явуулдаг сургалтад хамруулах.

1.4. Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын 2 багшийн нэг нь үндэсний спортын төрлийн багш байлгах бодлого баримтлах

1.5. Бүх сум үндэсний спортыг хөгжүүлэх орчинг бүрдүүлэх “Үндэсний спор-Хонгорчуудын бахархал” болзолт уралдаан, төрөл бүрийн арга хэмжээг хэрэгжүүлэх

1.6. Үндэсний спортын холбоодын ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх, жил бүр хэрэгжүүлсэн ажлын үр дүнг үнэлж дүгнэх урамшуулах

1.7. Үндэсний спортыг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжих, урамшуулах талаар журам боловсруулан хэрэгжүүлэх

1.8. Үндэсний спортын төрлүүдийг хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр орон нутгийн төсөөт тусгах, хэрэгжилтийг тайлагнадаг болох

1.9. Үндэсний спортын хэрэглэл материал, тоног төхөөрөмж үйлдвэрлэх, нийлүүлэх санал, санаачилгыг дэмжиж ажиллах

1.10. Бөхийн зодог шуудаг, дэвжээ, нум сүм, шагайн харвааны хашлага сүм хийдэг хувь хүн болон аж ахуй нэгжийн бизнесийг дэмжиж, Хөдөлмөр эрхлэлтийг

дэмжих сан, ЖДҮ-ийн сан болон бусад хөнгөлөлттэй зээл, төсөлд хамруулаж буцалтгүй дэмжлэг үзүүлэх.

Зорилт 2. Монголчуудын уламжлалт болон шинээр хөгжиж байгаа үндэсний спортыг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлж, улс, аймгийн алдар цолтой шилдэгүүдийг төрүүлж, алдаршуулан хонгорчуудын бахархал, үнэт соёл, баялгийг бүтээнэ.

Хүрэх үр дүн: “Монголчуудын уламжлалт болон шинээр хөгжиж байгаа үндэсний спортыг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлж, улс, аймгийн алдар цолтой шилдэгүүдийг төрүүлж,

2.1 Үндэсний спортын соёл зан үйл, техник арга барилын талаар сургалт сурталчилгааны материал, гарын авлага, CD, DVD бичлэгийг түгээх.

2.2 Улсын цол зэрэгтэй бөх тайлбарлагч, засуулч, морь цоллоочдын залуу үеийг бэлтгэх

2.3. Жил бүр бөх тайлбарлагч, морь, бөх цоллоочийн, аймгийн уралдааныг явуулж, шилдэгүүдийг тодруулах ур чадварыг хөгжүүлэх, урамшуулах

2.4. Үндэсний бөхийн дэвжээг Улаанбаатар хотод бий болгон үндэсний бөхөөр хичээллэгчид, бөхчүүдийг бусдаас суралцах, нэг удирдлагатай болох ажлыг хэрэгжүүлэх

2.5. Улс, аймгийн баяр наадмаар улс, аймгийн наадамд түрүүлсэн бөхчүүдийг дэмжих сан байгуулах, хэрэгжүүлэх журам боловсруулан мөрдөх

2.6. Үндэсний бөхийн аймгийн өсвөр үе, насанд хүрэгчдийн аварга шалгаруулах аймгийн Засаг даргын нэрэмжит “Хонгорын бөх” бөхийн баярыг 2 жилд 1 удаа зохион байгуулж байх

2.6. Шилдэг уяачдыг туршлагыг өвлүүлэх, залгамж халааг бэлтгэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх, Хонгор нутгийн шилмэл хурдан хүлэгтэй болох

2.7. Хурдан морь унаач хүүхдийн аюулгүй байдалд уяачид, эцэг эх, хүүхэд хамгааллын хамтарсан баг хамтран ажилладаг болгох

2.8. Уяач бүр уралдаанч хүүхдийн хамгаалалтын стандартын хувцасаар хангадаг болгох

2.9. Шилдэг уяачдын аймгийн зөвлөгөөнийг жил бүр хийж, уяачдыг алдаршуулах

2.10. Хонгор нутгийн бөхчүүд, хаарваачид, уяачдын амжилт бүтээлээр баримтад кино хийх. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хонгор нутгийн үндэсний спортын амжилтуудыг түгээх ажлыг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх

2.11. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, соёл урлагийн бүтээл, бизнесийн бүтээгдэхүүний нэр, шошгыг үндэсний спортын алдартануудын нэрээр нэрлэх ажлыг бодлогоор дэмжих

2.12. Сум, сургууль бүрт үндэсний спортын дугуйлан, секц, клуб ажиллуулахыг дэмжих,

2.13. Үндэсний спортын аймгийн бага наадмыг бөх, морин спорт, сурын харваа, шагайн харваа, шагайн наадгай, морь, бөхийн цоллоочоор 2 жил тутамд 1 удаа зохион байгуулах

2.14. Хот хөдөөгийн ахмад, өсвөр үе, бага наасны бөхчүүдийн уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах, туршлага солилцох

2.15. Үндэсний шагайн харваачдын ур чадварыг дээшлүүлж үйл ажиллагааг нь эрчимжүүлэхийн тулд 7 хоног бүрийн 4 дах өдрийн цуваа харваа, Тойром харваа, Холбооны цомын харваа, Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг өсвөр, насанд хүрэгчдийн ангиллаар зохион байгуулж байна.

2.16. Үндэсний сурын нээлтийн харваа, нэрэмжит харваанууд, тахилга харваа, аймгийн аварга шалгаруулах тэмцээн насанд хүрэгчид, өсвөр үе, отго харвааг зохион байгууллах.

2.17. Бүх сумдыг сур харвааны талбайтай болгох

2.18. Баянхонгор аймгийн Үндэсний сурын талбайг Монгол Улсын мэргэн Лхагвийн Ядамсүрэн агсаны нэрэмжит болгон хөшөө дурсгалын алдарыг мөнхжүүлэх.

2.19. Улсын баяр наадмаар эрийн гурван наадмын нэг сурын харвааг тогтмол зохион байгуулж, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн дагуу цол зэрэг, Засгийн газрын 2010 оны “Үндэсний их баяр наадмын сурын харвааны бай шагнал “ олгох тухай 271 дүгээр тогтоолыг аймгийн хэмжээнд мөрдөж ажиллах.

2.20. Аймгийн Үндэсний сурын талбайг тохижуулах наадамчид үзэгчдийн суудал, харваачдын сүүдрэвч асар, сурын холбооны ажлын байрыг хийж байгуулах. /Монголын үндэсний сурын холбооны сурын талбай, ажлын байрны жишгээр/

2.21. Бүх сумдын баг харваачдыг 5 ш нум, 100 ш сум, нэг бүтэн хасаа сур /62ш/ болон харвааны бусад хэрэглэгдэхүүнээр хангах.

2.22. Ерөнхий боловсролын сургуулиудыг хүүхдийн 2 нум, 10 сум нэг бүтэн хасс сур /62ш/ болон харвааны бусад хэрэглэгдэхүүнээр хангах.

2.23. Үндэсний их баяр наадмаар амжилт гаргасан Баянхонгор аймгийн харьят иргэнд мөнгөн урамшуулалыг олгоно.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга замууд

5.1. Хөтөлбөр боловсруулсан ажлын хэсэг хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцан орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхэд удирдлага арга зүйгээр хангаж ажиллана.

5.2 Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааны гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр аймгийн Засаг даргын захирамжаар хяналт тавих ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Биеийн тамир, спортын газрын дарга нарт үүрэг болгоно.

5.3 Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг жил бүр аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлсний дараа аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж үнэлүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Одоогийн түвшин 2017 он	2018 он	2020 он
1	Үндэсний спортыг хөгжүүлэх тогтолцоог аймаг, сум, багийн түвшинд бий болгосон байна.	байхгүй	3 түвшинд хариулагч хүнтэй болно	Тогтвортой тогтолцоотой болсон байна
2	Үндэсний бөхийн секц дугуйлан хичээлэгчдийн тооны өсөлт /Сургуулиуд/	10	15	25
3	Үндэсний шагайн харваагаар хичээллэгчдийн тооны өсөлт /сургуулиуд/	5	15	25
4	Үндэсний сурын спортоор хичээлэгчдийн тооны өсөлт /сургуулиуд/	6	11	25
5	Үндэсний спортын төрлийн багштай сургуулиуд	11	18	25

Долоо. Хэрэгжилтийн үнэлгээний арга хэлбэр, үе шат

7.1. Үндэсний спортын хөгжүүлэх хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

7.1.1. 1-р үе шат буюу 2017-2019 он /2019 оны 03 дугаар сард үнэлгээ хийх/

7.1.2. 2-р үе шат буюу 2019-2021 он /2021 оны 01 дүгээр сард үнэлгээ хийх/

7.2. Явцын үнэлгээ буюу мониторингийг 2 жил тутамд зохион байгуулж, эцсийн үнэлгээг 2021 онд зохион байгуулж, дүнг мэдээлж ажиллана.

7.3. Төлөвлөгөөний биелэлтийн явцыг аймгийн ажлын хэсэг аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргад мэдээлж, тайлагнах ба аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын

хэлтсийн тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн, аймгийн Биеийн тамир, спортын газар иргэдэд мэдээлэх ажлыг хариуцан зохион байгуулна.

7.4. Биелэлтийн явц, үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсээр дамжуулан аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлж ажиллана.

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын

удирдлага, зохион байгуулалт

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалт, аймаг, сумын нийгэм эдийн засаг, бусад төсөл хөтөлбөр, төсвийн санхүүжилттэй нягт уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах, хяналт тавих үүргийг аймгийн аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хариуцан аймгийн Биеийн тамир, спортын газар, Боловсрол, соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Үндэсний спортын холбоодын оролцоотойгоор хамтран хэрэгжүүлнэ.

Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт

9.1. Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

9.1.1. Улсын төсөв

9.1.2. Орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө

9.1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

9.1.4. Орон нутгийн хөгжлийг дэмжих сан

9.1.5. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хүрээнд хуваарилсан хөрөнгө

9.1.6. Дотоод, гадаадын хандивлагч байгууллагуудын зээл тусlamж, төсөл

9.1.7. Аж ахуй нэгж байгууллага, иргэдийн хандив, зээл тусlamж

Арав. Хяналт, үнэлгээ, тайлагналт

10.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт, үнэлгээ хийх ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг эрхлэн гүйцэтгэнэ. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ хийх ажлын хэсэгт Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Үндэсний спортын холбоод, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байна.

10.2. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээний ажлын зорилго нь хөтөлбөрт дэвшүүлсэн шалгуур үзүүлэлт, зорилтыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, туршлага, сургамжийг нэгтгэн дүгнэх, хөтөлбөрийг

санхүүжүүлэхэд зарцуулсан хөрөнгө үйл ажиллагааны үр дүнд хэрхэн хүрч, зохих дэмжлэг болж чадсаныг судалгаа, шинжилгээ, олон нийтийн оролцооны аргаар тогтоох, цаг үеийн байдалтай холбогдуулан хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах, зөвлөмж, санал дүгнэлт гаргана.

Арван нэг. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл

- 11.1 Монгол Улсын Үндсэн хууль
- 11.2 Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030
- 11.3 Биеийн тамир спортын тухай хууль
- 11.4 Баяр наадмын тухай хууль
- 11.5 Хүүхэд хамгааллын тухай хууль
- 11.6 Хөдөлмөрийн тухай хууль
- 11.7 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- 11.8 Хуульд нийцүүлэн гаргасан Засгийн газар, яам, тусгай газрын журам, тогтоолууд, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, Засаг даргын захирамж, бусад шийдвэрүүд

Арван хоёр. Хөтөлбөрийн шагнал урамшуулал

- 12.1. Үндэсний Их баяр наадамд амжилттай барилдаж шинээр улсын цол хүртсэн бөхчүүдэд олгох мөнгөн шагналын хэмжээ

№	Спортын төрөл	Начин	Харцага	Заан	Гарьд	Арслан
1	Үндэсний бөх	20 сая	30 сая	40 сая	50 сая	60 сая

- 12.2 Үндэсний Их баяр наадамд айрагдаж түрүүлсэн морьдын эзэдэд, унаач хүүхдэд олгох мөнгөн шагналын хэмжээ

№	Нэр	Aйрагдсан	Tүрүүлсэн
		5 сая	10 сая
1	Хурдан морь		
2	Унаач хүүхэд	30%	30%

- 12.3 Үндэсний Их баяр наадамд амжилттай оролцсон харваачдад олгох мөнгөн шагналын хэмжээ

№	Спортын төрөл	Цуваа харваа		
		Монгол Улсын Мэргэн	Монгол Улсын Гарамгай харваач	Монгол Улсын Гоц харваач
1	Үндэсний сур	20 сая	10 сая	5 сая

- 12.4 Үндэсний Их баяр наадамд амжилттай оролцсон харваачдад олгох мөнгөн шагналын хэмжээ

№	Спортын төрөл	Багийн харваа		
		3 байр	2 байр	1 байр
1	Үндэсний шагайн харваа	6 сая	8 сая	10 сая